



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Дорноговь АЗЗА” ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын
хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/10/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Багийн ахлагч аудитор:	Ш.Сувдаа
		Цахим хаяг: smaudit97@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021. 03.15 № 46/317

танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЗЗА ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ А.БАТТОГТОХ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дорноговь АЗЗА" ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Дорноговь АЗЗА" ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	855.9	556.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	725.2	586.0
	Нийт хөрөнгийн дүн	1,581.2	1,142.8
	Нийт өр төлбөрийн дүн	474.6	353.5
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,106.5	789.2
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,581.2	1,142.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,285.0	1,726.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	680,885.0	478,420.9
	Үйл ажиллагааны үр дүн	11,119.6	11,319.8
	Үйл ажиллагааны бус үр дүн	1,111.9	1,131.9
	Үйл ажиллагааны нийт үр дүн	10,007.6	10,187.8
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,256.2	1,256.2
	Тайлант оны үр дүн	(568.6)	(885.9)
	Эцсийн үлдэгдэл	1,106.5	789.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,535.4	2,009.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,385.7	2,103.7
	Үйл ажиллагааны ЦМГ	149.6	(93.8)
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(70,000.0)	(1.7)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(1.6)	(1.0)
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	77.9	96.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	53.4	131.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	131.4	34.9

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь АЗЗА ТӨХК нь “Зөв төлөвлөлт, чанартай бүтээн байгуулалт, үр дүнтэй хяналт” гэсэн зорилтын хүрээнд төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто зам, замын байгууламжийн засвар, арчлалтыг хариуцсан замын хэмжээнд зохион байгуулж түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг жилийн дөрвөн улирлын туршид бүрэн хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтыг тодорхойлон ажилласан байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитын явцад онцолсон асуудал гараагүй болно.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас томилж байгаа нь ТБОНӨ тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, ЗГ-ын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 2.10, 4.1.3 дахь заалттай нийцсэн байна.

“Дорноговь АЗЗА” ТӨХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг сарын 350.0-370.0 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд ТӨБЗГ-тай хамтран хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах талаар арга хэмжээ авсан байна

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 2.5 хувиар бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал гаргаагүй болно.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 95.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 95.6 сая төгрөгийн алдааг залруулж, 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 95.5 сая төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

- Бараа материалын урьдчилгаа төлбөр 71.8 сая төгрөгийг өглөг дансанд тусгалгүй ангилал буруу дансанд бүртгэсэн байсныг аудитын явцад залруулав.
- Орлого үр дүн, татварын тайлангийн хооронд 20.5 сая төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн байсныг аудитын явцад залруулав. Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын ТТ-11 тайлангийн дүн санхүүгийн тайлангаас 3.2 сая төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан байсныг аудитын явцад залруулав.

Зөвлөмж:

1. Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨ	1	1			1			
	НИЙТ								

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ОНӨ	4	95.6	3	95.6					1	0
	НИЙТ	4	95.6	3	95.6	-	-			1	0